

Сургалтын байгууллага, удирдах ажилтны хөгжил, менежмент хариуцсан ахлах мэргэжилтэн / Ерөнхий боловсрол / , Дондов Энхтулга

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.1. Багш, ажилтны мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулж, мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлэх.							
1	Ерөнхий боловсролын сургалтын байгууллагын хүний нөөцийн хөгжлийн чиглэлээр батлагдсан хууль, тогтоомж, шийдвэр, бодлогын баримт бичиг, дүрэм, журмын хэрэгжилтийг хангах.	Дүрэм, журмын хэрэгжилтийг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тоо, батлагдсан удирдамж, тайлан	Ерөнхий боловсролын сургалтын байгууллагын 250 захирал, сургалтын менежер нарт сургалт зохион байгуулсан	695 сургалтын байгууллагад 2-оос доошгүй үйл ажиллагаа	1.Боловсролын сайдын 2025 оны А/25 тоот тушаалаар батлагдсан "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны мэргэжлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны журам"-д заасан багшийн дадлагажуулах үйл ажиллагааны жишиг хөтөлбөр боловсруулж, сургалтын байгууллагуудад хүргэсэн.Жишиг хөтөлбөрийг боловсруулахдаа олон улсын туршлагыг судалж, мэргэжлийн бусад байгууллагууд, ерөнхий боловсролын сургуулийн багшийн хөгжил хариуцсан сургалтын менежерүүдийн санал, шүүмжийг тусгасан. Жишиг хөтөлбөр нь багш, ажилтан нар харилцан бие биеэ хүндэтгэх, хамтран суралцах, мэргэжлийн бие даасан байдалд хүндэтгэлтэй	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

				хандах зэргээр сэтгэлзүйн таатай орчин бүрдүүлэн ажиллахыг суурь зарчим болгосон. 2.Боловсролын сайдын 2024 оны 9 дүгээр сарын 19ний өдрийн А/95 дугаар тушаалаар "Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтанд мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журам" батлагдсан. Журмын Мэргэшлийн зэргийн бүртгэл, мэдээллийн сан бүлэгт "Боловсролын салбарын мэдээллийн систем нь багш, удирдах ажилтны мэргэшлийн зэргийн нэгдсэн бүртгэл мэдээллийг бүртгэх цахим сантай байна гэж заасан. Боловсролын сайдын А/95 -ын холбогдох заалт, 260,261 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор Боловсролын яам, Боловсролын мэдээлэл технологийн төвтэй хамтран системийн хөгжүүлэлт хийх ажлыг тайлант хугацаанд зохион байгууллаа. Эдгээр журмын хүрээнд цэцэрлэг, ЕБС-ийн багш удирдах ажилтны мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагаа зохион байгуулагдаж эхэлсэн бөгөөд Заах аргач, Тэргүүлэх багш мэргэшлийн зэргийн тушаал шийдвэр гаргах ажлууд сургалтын байгууллага болон аймаг нийслэлийн Боловсролын газруудад зохион байгуулагдсан. Журмын дагуу хүүхдийн цэцэрлэг, ЕБС-ийн багш удирдах ажилтнуудын Зөвлөх	
--	--	--	--	--	--

					багш мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагаа 2025 оны 11 сард багтаан зохион байгуулагдана.		
2	Ерөнхий боловсролын сургалтын байгууллагын удирдах ажилтны мэргэжлийн хөгжлийг дэмжих үндсэн сургалт зохион байгуулах.	Сургалтын батлагдсан удирдамж, хөтөлбөр, төлөвлөгөө, оролцогчдын тоо, хувь	Үндсэн сургалтад хамрагдсан удирдах ажилтан-353	Сургалтын байгууллагад 2,7,12 дахь жилдээ ажиллаж буй удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалт зохион байгуулж, зорилтот бүлгийн 80 хувийг хамруулах	Боловсролын сайдын 2025 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 25 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор "Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтыг 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөс 05 дугаар сарын 09-ний өдрүүдэд цахим сургалтын хэлбэрээр зохион байгууллаа. Сургалтад хамрагдвал зохих 307 удирдах ажилтны 269 буюу 87,6% нь хамрагдаж, удирдах ажилтны 191 нь буюу 71% нь амжилттай суралцаж батламж авлаа. Сургалтын агуулгыг төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулж, нийт 7 багш, судлаачтай хамтран боловсрууллаа. Сургалтын агуулга нь Эргэцүүлэлд суурилсан удирдахуй, Хичээлийн судалгаанд удирдлагын оролцоо, сургалтын менежер судлагдахуун бүрийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжидлтийг удирдлагаар хангах, сургуулийн менежмент сэдвүүдээр гүнзгийрүүлж судлах, ажлын байран дээрээ туршин хэрэгжүүлэх, бататгах, танхим болон цахим, ажлын байрны сургалтын үр дүнг эргэцүүлэн бүтээл хийх удирдах ажилтны өөрийн удирдлагатай, бие даан	2-р сар	100%

					суралцах үйлийг дэмжсэн. Үндсэн сургалтад хамрагдсанаар удирдах ажилтны удирдахууд гарч буй өөрчлөлт, үр дүн, сайн туршлагыг 2025 оны 5 дугаар сарын 14-ны өдрөөс 5 дугаар сарын 30-ны хооронд өдөр бүр Боловсролын ерөнхий газрын пэйж хуудсаар дамжуулан олон нийтэд сурталчилсан. Энэхүү түгээн дэлгэрүүлэх ажилд Дундговь, Орхон, Ховд аймгийн сургуулиудын сургалтын менежер, захирлуудын ажлыг сурталчлан, сургалтын үр дүнгээ хуваалцсан			
3	Багш, удирдах ажилтны хөгжлийг дэмжих платформд суурилсан цахим сургалтын сан бүрдүүлэх.	Платформд байршуулсан шаардлага хангасан цахим сургалтын тоо, чанар	0	Bagsh.edu.mn платформд модуль байршуулах	1	Боловсролын ерөнхий газар 2023-2024 оны хичээлийн жилд сургалтын байгууллагын багш удирдах ажилтнуудад зориулан 151 модулиар платформд суурилан сургалт зохион байгуулсан. Модуль сургалтад давхардсан тоогоор 99000 багш хамрагдсан бөгөөд суралцагчдын сэтгэл ханамжийн судалгаа, хөндлөнгийн мониторингоор хамгийн өндөр үнэлгээ авсан 12 модулийг боловсруулсан багтай гэрээ байгуулж, эдгээр модулиудыг ашиглан цахим сургалт зохион байгуулах эрх үүсгэсэн. Багш, ажилтан байгууллагын хөгжлийн газар 2025 оны эхний хагас жилд Багшийн хөгжлийг дэмжих Bagsh.edu.mn платформд модулийг байршуулж, сургалтын байгууллагын багш, удирдах ажилтнуудыг өөрсдийн хөгжлийн хэрэгцээнд үндэслэн цаг	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					хугацаа, орон зайнаас үл хамааран суралцах боломжийг олголоо. Сургалтад хамрагдсан багш, удирдах ажилтнууд 1 модулийг бүрэн судалвал 100 оноо цуглуулах бөгөөд үүнээс 70 оноо авбал Батламж авах эрхтэй болно. Энэхүү сургалтад хэрхэн хамрагдах талаар БЕГ-аас 7 хоног бүр аймаг нийслэлийн Боловсролын газрын дарга мэргэжилтнүүдэд зохион байгуулдаг цахим хурлаар мэдээлэл хүргэсэн бөгөөд багш, удирдах ажилтнууд энэхүү сургалтад өөрийн хэрэгцээнд нийцүүлэн хамрагдах боломжтой. Энэ жилийн сүүлийн хагаст модуль сургалтын тоог нэмэгдүүлж, багш, ажилтан нарт бие даан суралцаж, хөгжих боломж, нөхцөлийг нэмэгдүүлэхээр зорилгоор модулийн тоог 24-т хүргэх зорилт тавин ажиллаж байна. Хавсралт: 3 файл		
4	Багш солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх.	Хөтөлбөрийн батлагдсан удирдамж, төлөвлөгөө, оролцогчдын тоо, чанар	Сургалтын байгууллага-15, багш -20	-	Боловсролын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/25 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааны журам”-ын 2.1 дүгээр хэсэгт мэргэжлийн багш нарын бүлгийн үйл ажиллагааг өргөжүүлэн, шинэчлэх тухай заасан. Тус ажлын хүрээнд 2022	4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	100%

					онд Боловсролын ерөнхий газраас боловсруулж, хэрэгжүүлсэн "Мэргэжлийн хөгжлийн бүлгийн аргачлал"-ыг шинэчлэн боловсруулж, мэргэжлийн бусад байгууллагуудын саналыг тусган сайжруулж, сургалтын байгууллагуудад хүргэлээ. Сургалтын байгууллагад ажиллах явцад сайн туршлагыг илрүүлж "мэргэжлийн багш нарын бүлгийн сайн туршлагын сан"-д 50 туршлага бүрдүүлсэн. Энэ нь багш солилцооны хөтөлбөрийн эхлэл хэсэг бөгөөд сайн туршлагын санд материал ирүүлсэн багш нараасаа багш солилцооны хөтөлбөр хийж, харилцан туршлагаа солилцох ажлыг зохион байгуулна.		
5	Ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах ажилтанд мэргэшлийн “Зөвлөх”, “Тэргүүлэх” зэрэг олгох дүгнэлт гаргах.	Дүгнэлт гаргасан материалын тоо	ЕБС-ийн багш, ажилтны мэргэшлийн зэргийн дүгнэлт гаргасан материал 161, дүгнэлт гаргаж, зэрэг олгосон, бататгасан мэргэжлийн болон техникийн боловсролын багш, удирдах ажилтан-98	МБТБСБ-ын багш, удирдах ажилтны мэргэшлийн зэргийн дүгнэлт гарсан байх	Боловсролын сайдын 2024 оны 9 дүгээр сарын 19ний өдрийн А/95 дугаар тушаалаар "Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтанд мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журам" батлагдсан. Журмын Мэргэшлийн зэргийн бүртгэл, мэдээллийн сан бүлэгт "Боловсролын салбарын мэдээллийн систем нь багш, удирдах ажилтны мэргэшлийн зэргийн нэгдсэн бүртгэл мэдээллийг бүртгэх цахим сантай байна. гэж заасан. Боловсролын сайдын А/95 -ын холбогдох заалт, 260,261 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор Боловсролын яам, Боловсролын мэдээлэл технологийн төвтэй	4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					хамтран системийн хөгжүүлэлт хийх ажлыг тайлант хугацаанд зохион байгууллаа. Эдгээр журмын хүрээнд цэцэрлэг, ЕБС-ийн багш удирдах ажилтны мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагаа зохион байгуулж эхэлсэн бөгөөд Заах аргач, Тэргүүлэх багш мэргэшлийн зэргийн тушаал шийдвэр гаргах ажлууд сургалтын байгууллага болон аймаг нийслэлийн Боловсролын газруудад зохион байгуулагдсан. Журмын дагуу хүүхдийн цэцэрлэг, ЕБС-ийн багш удирдах ажилтнуудын Зөвлөх багш мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагаа 2025 оны 11 сард багтаан зохион байгуулагдана.		
6	Сургалтын байгууллагын “Мэргэжлийн бүлэг”-ийн үйл ажиллагаанд зөвлөн туслах, үндэсний хэмжээнд онол практикийн бага хурал зохион байгуулж, сайн туршлага бүхий МХБ-ийн сан бүрдүүлэх.	Зөвлөн тусалсан МХБ-ийн тоо, туршлага болохуйц МХБ-ийн тоо	Сургалтын байгууллага дээр 3800 МХБ ажиллаж байна.Туршлага болохуйц 45 МХБ-ийн сан бүрдсэн.	Үндэсний хэмжээнд сургалтын байгууллага 116	Боловсролын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/25 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааны журам”-ын 2.1 дүгээр хэсэгт мэргэжлийн багш нарын бүлгийн үйл ажиллагааг өргөжүүлэн, шинэчлэх тухай заасан. Тус ажлын хүрээнд 2022 онд Боловсролын ерөнхий газраас боловсруулж, хэрэгжүүлсэн "Мэргэжлийн хөгжлийн бүлгийн аргачлал"-ыг шинэчлэн боловсруулж, мэргэжлийн бусад байгууллагуудын саналыг тусган сайжруулж, сургалтын байгууллагуудад хүргэлээ. Мөн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	100%

					Багш, ажилтан, байгууллагын хөгжлийн газрын арга зүйчид нийслэл болон орон нутагт томилолтоор ажиллах явцдаа 63 сургалтын байгууллагын мэргэжлийн багш нарын бүлгийн үйл ажиллагаатай танилцаж, зөвлөн туслах үйл ажиллагаа хийсэн байна. Үүний үр дүнд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн 310 багшид мэргэжил, арга зүйн зөвлөгөө өглөө. Сургалтын байгууллагад ажиллах явцад сайн туршлагыг илрүүлж "мэргэжлийн багш нарын бүлгийн сайн туршлагын сан"-д 50 туршлага бүрдүүлсэн. Мөн цахим талбарт сургалтыг чанартай зохион байгуулахын тулд Боловсролын яамнаас Bagsh.edu.mn платформ дээрх "Мэргэжлийн багш нарын бүлгийн модуль" Starsoft ХХК-тай байгуулсан гэрээт ажлын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, мэргэжил, арга зүйн зөвлөмж өгөх ажлыг хариуцан зохион байгуулж байна. Гэрээний хүрээнд Starsoft ХХК, ЭЗХЕБЧХС төслийн багийн хамтарсан уулзалт хэлэлцүүлэг 4 удаа зохион байгуулсан. Уулзалт хэлэлцүүлгийн үр дүнд мэргэжлийн багш нарын бүлгээр ажиллах, хэрэгжүүлэх, дүгнэх, тайлагнах, үнэлэх үйл ажиллагааг цахим талбарт хэрэглэгчдэд ойлгомжтой, системийн талаасаа асуудалгүй болгох талаар анхаарч ажиллаж байна.	
--	--	--	--	--	--	--

7	Хамтын ажиллагаа, санамж бичгийн хүрээнд гадаад улсын Боловсролын газартай туршлага солилцох үйл ажиллагаа зохион байгуулах.	Туршлага солилцсон албан хаагчийн тоо, үр дүн	Нэгжийн 6 албан хаагч гадаад улсын Боловсролын байгууллагатай туршлага солилцох үйл ажиллагаанд хамрагдсан.	Туршлага солилцох үйл ажиллагаанд 4 мэргэжилтнийг хамруулсан байх	Боловсролын ерөнхий газар, Япон улсын Шизуока мужийн Боловсролын газартай байгуулсан санамж бичгийн хүрээнд 4 дэх жилдээ хамтран ажиллахаар санал солилцон хамтын ажиллагаагаа төлөвлөн ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу 2025 оны 09, 10 дугаар сард Монголын талаас туршлага судлах, харилцан суралцах үйл ажиллагаа зохион байгуулна. Мөн Солонгосын Вонжин хотын Боловсролын газартай хамтын ажиллагааны хүрээнд 6 арга зүйч, мэргэжилтэн туршлага судлах үйл ажиллагаанд 2025 оны 2 дугаар сард хамрагдаж, Өмнөд болон Хойд Солонгосыг энх тайвныг бэлгэдсэн дурсгалын газар, Солонгосын сурах бичгийн Woongjin компани, Starfield номын сан, их дээд сургуулийн үйл ажиллагаатай танилцаж туршлага судаллаа	4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	100%
8	Ерөнхий боловсролын сургуулийн багшийн хөгжил хариуцсан сургалтын менежерүүдийг чадавхжуулах сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах.	Сургалтын батлагдсан удирдамж, хөтөлбөр, төлөвлөгөө оролцогчдын тоо, хувь	ЕБС-ийн 250 сургалтын менежерийг сургалтад хамруулсан.	Ерөнхий боловсролын сургуулийн 650 сургалтын менежерийг сургалтад хамруулах	Монгол улсын боловсролын их сургуулийн дэргэдэх Багшийн хөгжлийг дэмжих үндэсний төв, Кембрижийн багшийн хөгжлийн PDQ төвийн хөтөлбөрийн сургалтын агуулгаар бэлтгэгдсэн 12 сургагч багш, Боловсролын ерөнхий газрын судлагдахуун хариуцсан мэргэжилтнүүд хамтран Ерөнхий боловсролын сургуулийн багшийн хөгжил хариуцсан сургалтын менежерийн хөгжлийг дэмжих, сургалтын байгууллагын багшийн хөгжлийн төвийн үйл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар	100%


					ажиллагааг идэвхжүүлэх, бэхжүүлэх зорилгоор танхим, цахим хосолсон сургалтыг 2025 оны 2 дугаар сард нийслэлд, 4 дүгээр сарын 23-ны өдрөөс 25ны өдрүүдэд орон нутагт нь зохион байгууллаа. .Сургалтын агуулгыг Кембрижийн боловсролын багшийн хөгжлийн PDQ төвийн сургалтын агуулгад суурилан, Монгол улсын Боловсролын яамны бодлого төлөвлөлттэй уялдуулан боловсруулсан. Сургалтын агуулгад идэвхтэй сургалтын арга зүй, эргэцүүлэлд суурилсан багшлахуй, нэгж болон ээлжит хичээлийн төлөвлөлтийг хэрхэн үр дүнтэй боловсруулах гэх мэт агуулгууд багтсан байв. Тус сургалтад ерөнхий боловсролын сургуулийн багшийн хөгжил хариуцсан сургалтын менежер-692, БГ-ын мэргэжилтэн-87, нийт 779 албан хаагч хамрагдлаа.Сургалтад хамрагдсан багш, удирдах ажилтнууд агуулгыг 100 хувь судалж, 100 оноо цуглуулах бөгөөд 70 онооноос дээш оноо цуглуулвал батламж авах эрх үүсэх бөгөөд 692 сургалтын менежерийн 71% амжилттай суралцаж батламж авсан байна. Сургалтад хамрагдсан менежерүүдийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгээр хэрэгцээнд нийцсэн, цаг үеэ олсон үр дүнтэй сургалт болсон гэсэн дүгнэлт гарсан байна.	
--	--	--	--	--	--	--


					Хавсралт: 1 файл		
9	ЕБС-ийн багш, ажилтны мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалтаас бусад олон талт (эрдэм шинжилгээний болон онол практикийн бага хурал, зөвлөгөөн, хэлэлцүүлэг, түншлэл, хамтын үйл ажиллагаа) ажлыг зохион байгуулах.	Сургалт, үйл ажиллагааны тоо	Сургалт-8, оролцогч-1211	Сургалтаас бусад үйл ажиллагаа 2-оос доошгүйг зохион байгуулах	Монгол Улсын Их Хурлын тамгын газар, Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороо, Боловсролын ерөнхий газар хамтран ерөнхий боловсролын сургуулийн “Ахлах ангийн сурагчдын санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх Level-UP хөтөлбөр”-ийг Увс, Завхан, Ховд, Архангай, Булган зэрэг аймгуудад болон нийслэлийн 3 дүүргийн 149 сургуульд хэрэгжүүллээ.Тус хөтөлбөрт нийслэл, орон нутгийн 5033 суралцагч багш, удирдах ажилтнууд хамрагдлаа.Тус хөтөлбөрийг хэрэгжүүлснээр ахлах ангийн сурагчдын санхүүгийн мэдлэгт тодорхой хувь нэмэр оруулж, өрхийн санхүүгээ удирдах, багаар хамтран ажиллах, сургуулийн багш, удирдах ажилтны санхүүгийн боловсрол, мэдлэг, ур чадварт чухал нөлөө үзүүлсэн. Мөн боловсролын салбарынхан банк санхүүгийн байгууллагын албан хаагчидтай ажиллаж, тэдний цаг нарийн баримталдаг, хариуцлагатай байдлаас суралцаж байгаа бол нөгөө талаас боловсролын салбарын ажилтан албан хаагчдад шаардлагатай асуудлуудыг ойлгож хамтран ажилласан чухал ажил болж болсон.	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	100%
3.1. Нэгжийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг мөрдөн ажиллах							
10	Ерөнхий газрын	Биелэлт /хувь/	100%	100%	Тайлант хугацаанд Боловсролын	1-р сар, 2-р	100%


	даргын шуурхай хурал, даргын зөвлөлийн хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллах				ерөнхий газрын даргын шуурхай хурал, даргын зөвлөлийн хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг ханган, шаардлагатай тоо баримт, мэдээллийг бүрдүүлж, товч мэдээлэл бэлтгэж ажиллалаа. Үүнд. Тухайлбал: Боловсролын сайдын А/63 Багшийн туслах бэлтгэх тухай, А/64 багшлах эрхийг гэрчилгээ олгох тухай тушаалын хэрэгжилт: Багшлах эрхийн гэрчилгээ олгох чиглэлээр 2025 оны 1 дүгээр сараас 5 дугаар сарын хооронд багшийн хөтөлбөртэй 5 их дээд сургууль багшаар ажиллах хүсэлтэй иргэдийг сургалтад хамруулж, 5 сарын 17-ны байдлаар 129 иргэн багшлах эрхийн гэрчилгээ авсан байна. Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос санаачлан зохион байгуулсан төвийн бүсийн боловсролын байгууллагын удирдлагын сургалт зөвлөгөөнийг 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр төрийн ордонд зохион байгуулж, Төв, Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн Боловсролын газрын дарга, мэргэжилтэн, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн захирал 400 албан хаагчийг хамруулж, зохион байгуулалтыг хангаж ажиллалаа. Мөн ERP цахим системээр 100 албан бичиг ирснийг 92 ажил, албан хүсэлтийг шийдвэрлэж, 8 ажил шийдвэрлэх шатандаа явж	сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	
--	--	--	--	--	---	--	--


					байна.		
11	Архив, албан хэрэг хөтлөлтийн журмыг хэрэгжүүлж, эрхлэх асуудлын чиг үүрэгт хамаарах мэдээ, мэдээлэл, тайлан, холбогдох материалыг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын нэгж болгон хадгалуулах	Биелэлт /хувь/	100%	100%	Тайлант хугацаанд БАБХГ-ын эрхлэх асуудлын чиг үүрэгт хамаарах мэдээ, мэдээлэл, тайлан, холбогдох материалыг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын нэгж болгон хадгаллаа. Үүнд: Дараах чиглэлээр нийт 39 ботийг архив, албан хэрэг хөтлөлтийн журмыг дагуу үүсгэсэн. 1. Багш ажилтан, байгууллагын хөгжлийн газрын болон албан хаагчдын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан 4 боть 2. БАБХГ-аас зохион байгуулсан үндсэн болон модуль сургалт, бусад сургалт зөвлөгөөн, багшийн мэргэжлийн зэрэг, дотуур байр, нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлсэн 15 боть 3. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын захирлын гүйцэтгэлийн төлөвлөгөө, үр дүнгийн гэрээ, гэрээний биелэлт, үнэлгээний ажлын хэсгийн мэдээлэл, тушаал шийдвэр, тайлан, багшлах эрхийн сургалтын тушаал, хөтөлбөр тайлан 17 боть 4. Аймаг нийслэлийн БШУГ-ын мэргэжилтэн, удирдах ажилтны болон судлагдахууны мэргэжилтнүүдийн мэдээлэл солилцох уулзалт, туршлага судлах сургалт үйл ажиллагааны хөтөлбөр тайлан 3 боть материалын тус тус дэвтэрлэж, байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэжилтэнд	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%


1	Байгууллагын хүний нөөцийг чадавхжуулах дотоодын сургалтуудад хамрагдах	Сургалтын тоо	Байгууллагаас зохион байгуулсан 2 сургалт, үйл ажиллагаанд хамрагдсан.	50 хувь	“Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын үнэлгээ баталгаажуулалтын 16 цагийн багц сургалтад хамрагдаж “Хөндлөнгийн баталгаажуулагч”-аар ажиллах эрх олгох багшийн 20240021 тоот батламж авсан. “Насан туршийн суралцахуй, Боловсролын эко систем” Насанд хүрэгчдийн боловсрол номыг уншиж судалж байна.	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	100%
2	Ажил үүргийн холбогдолтой шинээр батлагдсан хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийг судлах	Шинээр баталсан хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийн тоо	2024 онд шинээр баталсан хууль-1, тогтоол-2, журам хоёрыг судалж ажилдаа тусган хэрэгжүүлсэн.	50 хувь	Засгийн газрын 2025 оны 02, 43, 158, 215, 218 дугаар тогтоолоор батлагдсан "Хяналт-шинжилгээ хийх журам", "Үнэлгээ хийх журам", "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам", 2026 оныг "Боловсролыг дэмжих жил" болгон зарлах, “Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, зээлийг эргэн төлүүлэх журам”, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” болон “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 02 дугаар албан даалгавар, “Хүйтний улиралд ажлын цагийн зохицуулалт хийх” Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 10 дугаар	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%






























Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагын хөгжил, менежмент хариуцсан ахлах мэргэжилтэн, Цэвэгжав Цасцэцэг

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
1.1.1. Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагын хүний нөөцийн хөгжлийг дэмжих сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах							
1	Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагын удирдах ажилтны ёс зүйн хэм хэмжээний зөрчил гаргах, авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх үйл ажиллагааг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах	Зохион байгуулсан сургалтын тоо, хамтарсан мэргэжлийн байгууллагын тоо, түгээсэн мэдээлийн тоо	1 удаагийн сургалт зохион байгуулсан	Сургалт, нөлөөллийн 1 арга хэмжээ зохион байгуулж, мэргэжлийн байгууллагатай хамтарч тухай бүр мэдээллийг түгээсэн байна.	Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагын удирдах ажилтны ёс зүйн хэм хэмжээний зөрчил гаргах, авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх үйл ажиллагааг АТГ-ын Соён гэгээрүүлэх хэлтэс болон БЕГ-ын Хууль, эрх зүйн хэлтэстэй хамтран 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр, 05 дугаар сарын 12-ний өдрийн "Мэдээлэл солилцох" цахим уулзалтаар зохион байгуулсан бөгөөд 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн удирдах ажилтан, мэргэжилтнүүд нийт 248 хүн хамрагдсан. Тус уулзалтаар салбарын хэмжээнд түгээмэл тулгамдаж буй хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахад 5 чиглэлийн хүрээнд	5-р сар, 10-р сар	100%

					анхаарч ажиллах талаар зөвлөмж, мэдээллийг хүргэж ажилласан. 21 аймаг, 9 дүүргийн Боловсролын салбарын мэдээ мэдээллийг олон нийтэд сурталчлах, мэдээлэл нээлтэй байх чиглэлийн хүрээнд бэлтгэн хуваарийн дагуу БЕГ-ын пэйж хуудсаар олон нийтэд хүргэсэн. Хавсралт: 17 файл		
2	Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагын хөгжил, менежментийн чиглэлээр төр, төрийн бус байгууллага, их дээд сургууль, бусад мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах	Хамтран ажилласан арга хэмжээний тоо	1	Хамтын ажиллагаа сайжирсан байна	“Илгээлтийн багш” нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллагатай хамтран “Teach for Mongolia” зорилтот хөтөлбөрийг 2024-2025 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллалаа. Энэ хүрээнд хөтөлбөрийн 4 дэх төслийн сонгон шалгаруулалтын зар болон зохион байгуулалтын талаарх мэдээллийг 21 аймгийн Боловсролын газарт хүргэж, БЕГ-ын пэйж хуудсаар сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зэргээр хамтран ажилласан. Боловсролын чанар хүртээмжийг технологийн давуу талыг ашиглан нэмэгдүүлэх зорилгоор Боловсролын ерөнхий газар, Хангай дээд сургуультай хамтран зохион байгуулж буй хиймэл оюун ухааны сургагч багш бэлтгэх анхан шатны сургалтад хамрагдсан 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн бага ангийн болон мэдээлэл зүйн багш нар ажмжилттай хамрагдаж төгссөн сургалтын талаарх 2	5-р сар, 9-р сар	100%

				удаагийн мэдээг бэлтгэн БЕГ-ын пэйж хуудсаар сурталчлан түгээсэн. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газар нь Монголын Ардын болон Гавьяат багш нарын холбоотой Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг үндэслэн сургуулийн менежментийг сайжруулах чиглэлээр хамтран ажиллах санамж бичгийн төсөл боловсруулсан.БЕГ-ын пэйж хуудсанд мэдээллийг бэлтгэн оруулсан.Өмнөговь аймгийн Боловсролын газрын санаачлагаар Удирдлагын академийн Төрийн албаны сургуультай хамтран "Албан хаагчдын ур чадварыг хөгжүүлэх нь" сэдэвт 20 цагийн сургалтад 2025 оны 04 дүгээр сарын 07, 08-ны өдрүүдэд нийт 17 албан хаагчид 20 цагийн хичээл судлаж гэрчилгээгээ гардаж авсан.Нөхцөл байдлын шинжилгээний үр дүнг нэгтгэх, хэлэлцэх сэдвүүдийг онол, дадлага ажлаар хамтран суралцаж мэргэжил, мэдлэгээ дээшлүүлсэн.Увс аймгийн Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээг 2025 оны 02 дугаар сарын10-14-ний өдрүүдэд " Ур чадварын үнэлгээнд ажил олгогч, үнэлгээний ажилтны хамт түүвэрт сонгогдсон суралцагчийн чадамжийг үнэлэн оролцож, тус		
--	--	--	--	--	--	--

					аймагт байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээг зохион байгуулсан талаар БЕГ-ын пэйж хуудсаар мэдээг оруулсан. Хавсралт: 21 файл		
3	Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагын удирдах ажилтны “Мэдээлэл солилцох цахим, уулзалт, хурал”-ыг зохион байгуулах	Зохион байгуулсан уулзалт, хурлын тоо Батлагдсан хөтөлбөрийн тоо, Оролцогчдын тоо	44	Мэдээлэл солилцох уулзалтыг 13 удаа зохион байгуулсан байна.	Тайлангийн хугацаанд боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагын удирдах ажилтанд зориулсан мэдээлэл солилцох цахим хурал, уулзалтын бэлэн байдлыг хангаж, цахим хурлыг 2025 оны эхний хагас жилийн хугацаанд нийт 20 удаа зохион байгууллаа. Энэхүү хурал, уулзалтаар салбарын хэмжээнд шинээр батлагдсан хууль тогтоомж, бодлого, шийдвэрийг танилцуулах, цаг үеийн шаардлагын улмаас хэрэгжүүлэх арга хэмжээ, анхаарах асуудлын талаар нэгдсэн ойлголтод хүрэх, зөвлөгөө өгөх, харилцан мэдээлэл солилцох зорилгоор 7 хоногийн Мягмар гараг бүр зохион байгуулж байна. Уг хурал, уулзалтын үеэр зохион байгуулагч талаас хийгдсэн мэдээллийг орон нутгийн боловсролын газруудад цахим шуудангаар хүргүүлж ажиллаж хэвшсэн. Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагын удирдах ажилтанд зориулсан мэдээлэл солилцох цахим хурал, уулзалтыг 2025 оны 01 дүгээр сараас 2025 оны 06 дугаар сарын хугацаанд нийт 20	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					удаа зохион байгуулсан. Энэ 20 удаагийн уулзалт, сургалтаар 6-8 чиглэлийн хүрээнд 121 мэдээ, мэдээллийг давхардсан тоогоор нийт 13570 удирдах ажилтан, ахлах мэргэжилтэн, мэргэжилтнүүдэд хүргэж, холбогдох дээд шатны байгууллага болон БЕГ-ын газар, хэлтсийн дарга, мэргэжилтнийг урин оролцуулах зэргээр хамтран ажилласан. Дээрх 20 удаагийн уулзалт, сургалтад боловсролын салбарын хэмжээний хөрөнгө оруулалтын чиглэлээр 14, санхүү, төсвийн чиглэлээр 8, цахим сүлжээ, цахим худалдан авалт чиглэлээр 12, багш мэргэжлийн тасралтгүй хөгжил чиглэлээр 16, сургалтын хөтөлбөр, үнэлгээ чиглэлээр 18, хяналт, шинжилгээ, үнэлгээний чиглэлээр 6, хууль эрх зүйн чиглэлээр 9, Захиргаа упирдлагын газраас 6, холбогдох дээд шатны байгууллагаас 18 удаагийн уулзалтаар зөвлөмж, зөвлөгөө, арга зүйн дэмжлэг үзүүлж хамтран ажилласан байна. Хавсралт: 17 файл		
4	Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагын судлагдахуунаас бусад асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд	Зохион байгуулсан уулзалт, хурлын тоо, батлагдсан хөтөлбөрийн тоо, оролцогчдын тоо	22	Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагын судлагдахуунаас бусад асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд	21 Аймаг, нийслэл 9 дүүргийн хэлтсийн судлагдахуунаас бусад чиглэл хариуцсан мэргэжилтнүүдэд салбарын бодлого, чиглэлийг танилцуулах, ажлын байранд нь дэмжих, арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор "Мэдээлэл солилцох цахим	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар,	100%

	арга зүйн дэмжлэг үзүүлэх “Мэдээлэл солилцох цахим, уулзалт, сургалт”-ыг зохион байгуулах			арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтыг 12 удаа зохион байгуулсан байна.	уулзалт” сургалтыг 2025 оны 1 дүгээр сараас 06 дугаар сарын хугацаанд хөтөлбөр, хуваарийн дагуу 12 удаагийн сургалтад давхардсан тоогоор 558 мэргэжилтнүүдийг хамруулсан бөгөөд БЕГ-ын 8 газар, 5 хэлтэстэй хамтран зохион байгуулсан. Мөн Энэхүү уулзалт, сургалтаар салбарын хэмжээнд шинээр батлагдсан хууль тогтоомж, бодлого, шийдвэрийг танилцуулах, цаг үеийн шаардлагын улмаас хэрэгжүүлэх арга хэмжээ, анхаарах асуудлын талаар нэгдсэн ойлголтод хүрэх, зөвлөгөө өгөх, харилцан мэдээлэл солилцох, арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор 7 хоногийн Пүрэв гараг бүр зохион байгуулж хэвшсэн. Уг уулзалт, арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтын мэдээллийг орон нутгийн Боловсролын газруудад цахим шуудангаар 86 мэдээ мэдээллийг хүргүүлж ажилласан. Хавсралт: 4 файл	11-р сар, 12-р сар	
5	Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагын удирдах ажилтан, мэргэжилтнүүдийг гадаад улс орны боловсролын байгууллагын үйл ажиллагаатай	Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо, хамрагдсан удирдах ажилтан, мэргэжилтний тоо, байгууллагын тоо	Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагын / БГ-ын/ 6 удирдах ажилтан, 17 мэргэжилтэн, 2 ЕБС-ийн	Гадаад улс орны ижил түвшний 1 байгууллагын үйл ажиллагаатай танилцуулах, туршлага судлах, богино хугацааны сургалтад хамруулсан байна.	АНУ-ын Вашингтон, Нью-Йорк хотуудад 2025 оны 5 дугаар сарын 12-наас 19-ний өдрүүдэд зохион байгуулагдсан удирдлагын манлайлал сургалт, туршлага судлах үйл ажиллагаанд БЕГ, аймаг, нийслэлийн Боловсролын газрын дарга, мэргэжилтнүүд болон цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн төлөөлөл	4-р сар, 10-р сар	100%

	танилцуулах, туршлага судлах, сургалтад хамрагдах ажлыг зохион байгуулах		захирал Тайвань улсын боловсролын байгууллагын үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах, сургалтад хамрагдсан.		болох 9 хүнийг хамруулсан. “Удирдлагын манлайлал сургалт, туршлага судлах үйл ажиллагаа”-ны зорилго нь АНУ-ын боловсролын салбар дахь сургалт үйл ажиллагааны онцлогийг судлах, зарим их дээд сургууль, ЕБС дээр очиж бодит орчин нөхцөлтэй танилцаж, туршлага судлах байлаа. АНУ-ын Вашингтон хотод зохион байгуулагдсан богино хугацааны сургалт, туршлага судлах үйл ажиллагаанд орон нутгийн төрийн захиргааны байгууллагын удирдах ажилтнуудыг ахлан оролцсон талаарх тайлан танилцуулгыг аймгийн Боловсролын газрын дарга нарын 2025 оны 06 дугаар сарын 03 -ны өдрийн "Мэдээлэл солилцох цахим уулзалт"-ын цагаар танилцуулж мэдээллээ солилцсон. Мөн БЕГ-ын пэйж хуудсанд мэдээлэл оруулж бусдад түгээн дэлгэрүүлсэн. Солонгос улсын Сэ жун хотын захиргаа, Боловсролын газартай уулзалтад оролцож, ирээдүйн боловсролын чиг хандлага, боловсролын бодлого, хамтын ажиллагааны төлөвлөгөөний талаар санал солилцож, сургалтад хамрагдсан. Хавсралт: 10 файл		
3.1. Нэгжийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг мөрдөн ажиллах							
6	Авлигын эсрэг хууль, нийтийн албанд нийтийн	Хөрөнгө орлогын мэдүүлэг цаг хугацаанд	1	Хөрөнгө орлогын мэдүүлгийг хугацаандаа	Авлигын эсрэг хуулийн 10.3-т заасны дагуу "2024 оны хөрөнгө орлогын мэдүүлэг"-ийг 2025 оны 01	1-р сар, 6-р сар,	100%

	болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх	мэдүүлсэн байх		тайлагнасан байна.	дүгээр сарын 16-ны өдөр https://meduuleg.iaac.mn/AOS/Login цахим системээр илгээж, баталгаажуулсан.	12-р сар	
7	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх	Ирсэн албан бичиг, өргөдөл, гомдлын тоо, тэдгээрийн шийдвэрлэлтийн хувь	21	Албан бичиг, өргөдөл гомдлыг хуульд заасан хугацаанд шийдвэрлэсэн байна.	Тайлангийн хугацаанд Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд заасны дагуу эрхлэх асуудлаар 6 боть материалыг хадгаламжийн нэгж үүсгэн байгууллагын архивд 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр хүлээлгэн өгсөн. Мөн иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн 6 өргөдөл, гомдол, 12 албан бичгийг хуулийн хугацаанд бүрэн барагдуулснаас гадна нийт 32 албан бичиг, удирдамж, хөтөлбөрийн төсөл боловсруулж, холбогдох удирдах ажилтнаар хянуулан баталгаажуулан хүргүүлсэн байна. Харин Авлигын эсрэг хуулийн 10.3-т заасны дагуу "2024 оны хөрөнгө орлогын мэдүүлэг"-ийг 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр https://meduuleg.iaac.mn/AOS/Login цахим системээр илгээж, баталгаажуулсан. Хавсралт: 7 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

8	Ерөнхий газрын даргын шуурхай хурал, даргын зөвлөлийн хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллах	Өгсөн үүрэг даалгаврын тоо	8	Үүрэг даалгаврыг чанартай гүйцэтгэж тайлагнасан байна.	БЕГ-ын дарга болон нэгжийн даргын дараах 9 чиглэлийн хүрээнд өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь чанартай гүйцэтгэж тайлагнаж ажилласан.Үүнд: *Сургуулийн барилгын өргөтгөл, 640 суудалтай (Дорнод аймгийн Хэрлэн сумын 12 дугаар сургуулийн дотуур 320 хүүхдийн сургуулийн өргөтгөлийн барилга, Увс аймгийн дотуур байрны тоног төхөөрөмж, СХД-ийн тендер шалгаруулалтын үнэлгээний хорооны гишүүнээр ажиллаж /4 удаагийн хуралд танхимаар оролцож үнэлгээ хийж ажилласан. * Боловсролын газрын бүсийн хэмжээний сайн туршлагаа судлах, хамтран суралцах, сургалт үйл ажиллагаа зохион байгуулах удирдамж, хөтөлбөрийн төсөл боловсруулан 21 аймаг, нийслэл 9 дүүргээс санал авч ажилласан. *2024 онд зөвлөх мэргэшлийн зэрэг авахаар ирүүлсэн багш, удирдах ажилтны материалыг магадлах, дүгнэлт гаргах ажлын хэсгийн нарийн бичгээр ажилласан. *2024 онд зөвлөх мэргэшлийн зэрэг авсан багш, удирдах ажилтны зөвлөх мэргэшлийн зэргийн үнэмлэх олгох, хуваарилах ажлыг зохион байгуулан олгосон. * Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газар нь Монголын Ардын болон Гавьяат багш нарын холбоотой Монгол	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
---	---	----------------------------	---	--	--	--	------

					Улсын холбогдох хууль тогтоомжийг үндэслэн сургуулийн менежментийг сайжруулах чиглэлээр хамтран ажиллах санамж бичгийн төсөл боловсруулсан.БЕГ-ын пэйж хуудсанд мэдээллийг бэлтгэн оруулсан .* Боловсролын ерөнхий газар, Хангай дээд сургуультай хамтран зохион байгуулж буй хиймэл оюун ухааны сургагч багш бэлтгэх анхан шатны сургалтад хамрагдсан 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн бага ангийн болон мэдээлэл зүйн багш нар ажмжилттай хамрагдаж төгссөн талаарх 2 удаагийн мэдээг бэлтгэн БЕГ-ын пэйж хуудсаар сурталчлан түгээсэн. * БЕГ-ын дарга Увс аймгийн Боловсролын газарт ажиллах хугацааны хөтөлбөр гаргах, зохион байгуулалтын хийж ажилласан. *Ахлах ангийн сурагчдад санхүүгийн боловсрол олгох "Level-Up" хөтөлбөрийг хэрэгжүүлэх нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулах бэлтгэл ажлыг Увс аймгийн Боловсролын газартай хамтран зохион байгуулсан. *БС-ын 2024 оны А/175-р тушаалын хэрэгжилт Хавсралт: 16 файл		
--	--	--	--	--	---	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
---	-----------------	---------------	---------

1	2	3	4
---	---	---	---

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Богино хугацааны монгол бичгийн сургалтад хамрагдах	Онлайн сургалтад бүрэн хамрагдах	1	Сургалтад хамрагдсан байна.	“Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын үнэлгээ баталгаажуулалтын 16 цагийн багц сургалтад хамрагдаж “Хөндлөнгийн баталгаажуулагч”-аар ажиллах эрх олгох багшийн 20240029 тоот батламж авсан. “НАСАНД ХҮРСЭН СУРАЛЦАГЧ” Насанд хүрэгчдийн бодловсрол болон Хүний нөөцийн хөгжлийн сонгодог сурах бичиг номыг уншиж судалж байна. Хавсралт: 2 файл	5-р сар, 10-р сар	100%
2	Шинээр батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг судлах	Шинээр батлагдсан нийтээр дагаж мөрдөх хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актыг судлах, бүртгэх	28	Судалсан хууль тогтоомж, тогтоол шийдвэр (тоогоор)	Засгийн газрын 2025 оны 02, 43, 158, 215, 218 дугаар тогтоолоор батлагдсан “Бүсийн зөвлөлийн ажиллах журам”, "Хяналт-шинжилгээ хийх журам", "Үнэлгээ хийх журам", "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам", 2026 оныг "Боловсролыг дэмжих жил" болгон зарлах, “Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, зээлийг эргэн төлүүлэх журам”, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

